



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/169/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066      Цахим хаяг: <a href="mailto:peakomaudit@gmail.com">peakomaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН  
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.ҮҮРЦАЙХ ТАНАА**

2022.02.25 № СЭА-2022/169-НА-СТА-ТШЗ

танил \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,602,478.42</b>	<b>50,331,309.42</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>42,602,478.42</b>	<b>50,331,309.42</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>37,179,335.42</b>	<b>16,685,081.42</b>
35110	Тусгай зориулалттай материал	37,009,135.42	16,380,281.42
35130	Эм боох материал	170,200.00	304,800.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>5,423,143.00</b>	<b>33,646,228.00</b>
35420	Аж ахуйн материал	5,423,143.00	174,591.00
35470	Бусад хангамжийн материал	0	33,471,637.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>476,966,114.51</b>	<b>429,395,115.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>476,966,114.51</b>	<b>429,395,115.31</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>454,546,289.54</b>	<b>407,287,790.38</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	503,710,170.02	503,710,170.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-102,096,721.83	-137,837,024.36
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	48,154,258.40	45,199,122.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,510,233.18	-21,736,429.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,706,722.14	27,251,572.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,442,089.33	-12,597,914.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,272,936.52	6,272,936.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,248,753.20	-2,974,641.92
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>22,419,824.97</b>	<b>22,107,324.93</b>
39301	Програм хангамж	1,650,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-634,375.03	-546,875.07
39303	Бусад биет бус хөрөнгө	21,404,200.00	21,404,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>519,568,592.93</b>	<b>479,726,424.73</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,049,706.30</b>	<b>53,589,266.10</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,049,706.30</b>	<b>53,589,266.10</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>51,049,706.30</b>	<b>53,589,266.10</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>51,049,706.30</b>	<b>53,589,266.10</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	51,049,706.30	53,589,266.10
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>468,518,886.63</b>	<b>426,137,158.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>468,518,886.63</b>	<b>426,137,158.63</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	533,912,670.00	533,912,670.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-498,693,093.70</b>	<b>-541,074,821.70</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-485,582,226.71	-498,693,093.70
51220	Тайлант үеийн үр дүн	-13,110,866.99	-42,381,728.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,299,310.33	433,299,310.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>519,568,592.93</b>	<b>479,726,424.73</b>

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>670,837,082.92</b>	<b>649,164,246.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,609,782.92</b>	<b>601,546.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>25,609,782.92</b>	<b>601,546.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	25,293,142.92	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	316,640.00	601,546.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>645,227,300.00</b>	<b>648,562,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>537,181,100.00</b>	<b>541,988,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	537,181,100.00	541,988,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,120,000.00</b>	<b>544,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,120,000.00	544,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>106,926,200.00</b>	<b>106,030,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,926,200.00	106,030,600.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>683,794,509.91</b>	<b>691,334,574.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>683,794,509.91</b>	<b>691,334,574.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>617,404,217.91</b>	<b>651,926,383.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>387,148,841.00</b>	<b>402,391,915.00</b>
210101	Үндсэн цалин	225,416,103.00	295,064,602.00
210102	Нэмэгдэл	130,191,673.00	76,030,426.00
210104	Урамшуулал	31,541,065.00	31,296,887.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,385,037.00</b>	<b>54,409,394.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,901,826.00	38,435,418.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,870,803.00	4,226,020.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,096,641.00	3,242,475.00
210204	Ажилгүйдлийн даатгал	774,161.00	765,798.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,741,606.00	7,739,683.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,850,324.77</b>	<b>107,170,159.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,659,071.00	7,259,789.00
210302	Түлш, халаалт	81,462,148.77	93,515,221.80
210303	Цэвэр, бохир ус	4,729,105.00	6,395,149.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,823,224.98</b>	<b>6,758,815.00</b>
210401	Бичиг хэрэг	920,000.00	1,158,320.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,430.00	762,280.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	974,200.00	1,772,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,522,200.00	1,258,300.00
210408	Бараа материал акталсны зардал	2,630,394.98	1,607,615.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>13,317,000.00</b>	<b>23,990,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,000.00	154,200.00
210502	Хоол, хүнс	13,179,000.00	23,289,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,000.00	546,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,429,200.00</b>	<b>2,419,800.00</b>
210604	Урсгал засвар	4,429,200.00	2,419,800.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>279,000.00</b>	<b>380,000.00</b>

**Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210702	Дотоод албан томилолт	279,000.00	380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>714,000.00</b>	<b>1,572,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,457,590.16</b>	<b>52,834,199.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,815,000.00	1,463,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,042,590.16	51,370,999.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,390,292.00</b>	<b>39,408,191.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>66,390,292.00</b>	<b>39,408,191.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,390,292.00	39,408,191.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-12,957,426.99</b>	<b>-42,170,328.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>153,440.00</b>	<b>211,400.00</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	153,440.00	211,400.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-13,110,866.99</b>	<b>-42,381,728.00</b>

### **2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>645,227,300.00</b>	<b>648,562,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>645,227,300.00</b>	<b>648,562,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>537,181,100.00</b>	<b>541,988,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	537,181,100.00	541,988,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,120,000.00</b>	<b>544,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,120,000.00	544,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>106,926,200.00</b>	<b>106,030,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,926,200.00	106,030,600.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>633,967,300.00</b>	<b>644,762,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>633,967,300.00</b>	<b>644,762,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>567,577,008.00</b>	<b>605,354,509.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>387,148,841.00</b>	<b>402,391,915.00</b>
210101	Үндсэн цалин	225,416,103.00	295,064,602.00
210102	Нэмэгдэл	130,498,338.00	76,030,426.00
210104	Урамшуулал	31,234,400.00	31,296,887.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,385,037.00</b>	<b>54,409,394.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,901,826.00	38,435,418.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,870,803.00	4,226,020.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,096,641.00	3,242,475.00
210204	Ажилгүйдлийн даатгал	774,161.00	765,798.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,741,606.00	7,739,683.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>106,097,000.00</b>	<b>104,630,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,659,071.00	7,259,789.00
210302	Түлш, халаалт	94,708,824.00	90,975,662.00
210303	Цэвэр, бохир ус	4,729,105.00	6,395,149.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,253,830.00</b>	<b>5,236,700.00</b>

**Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	920,000.00	1,158,320.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,430.00	762,280.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,145,200.00	1,702,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,412,200.00	1,413,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,740,100.00</b>	<b>32,850,900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,000.00	154,200.00
210502	Хоол, хүнс	11,420,100.00	23,289,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	9,406,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,429,200.00</b>	<b>2,419,800.00</b>
210604	Урсгал засвар	4,429,200.00	2,419,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>279,000.00</b>	<b>380,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	279,000.00	380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>714,000.00</b>	<b>1,572,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,530,000.00</b>	<b>1,463,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,930,000.00	1,463,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,390,292.00</b>	<b>39,408,191.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>66,390,292.00</b>	<b>39,408,191.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,390,292.00	39,408,191.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>11,260,000.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,260,000.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,260,000.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,260,000.00</b>	<b>3,800,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,260,000.00	3,800,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-11,260,000.00</b>	<b>-3,800,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>0</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	441,170,470.33	(493,453,386.71)	481,629,753.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,871,160.00	7,871,160.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,912,670.00	441,170,470.33	(485,582,226.71)	489,500,913.62
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(7,871,160.00)	-	(7,871,160.00)

**Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,110,866.99)	(13,110,866.99)
<b>10</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>533,912,670.00</b>	<b>433,299,310.33</b>	<b>(498,693,093.70)</b>	<b>468,518,886.63</b>
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>533,912,670.00</b>	<b>433,299,310.33</b>	<b>(498,693,093.70)</b>	<b>468,518,886.63</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(498,693,093.70)	468,518,886.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(42,381,728.00)	(42,381,728.00)
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>533,912,670.00</b>	<b>433,299,310.33</b>	<b>(541,074,821.70)</b>	<b>426,137,158.63</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>648,018,700.00</b>	<b>608,610,509.00</b>	<b>39,408,191.00</b>	<b>93.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>648,018,700.00</b>	<b>608,610,509.00</b>	<b>39,408,191.00</b>	<b>93.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>648,018,700.00</b>	<b>608,610,509.00</b>	<b>39,408,191.00</b>	<b>93.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>424,123,900.00</b>	<b>402,391,915.00</b>	<b>21,731,985.00</b>	<b>94.88</b>
210101	Үндсэн цалин	295,652,400.00	295,064,602.00	<b>587,798.00</b>	<b>99.80</b>
210102	Нэмэгдэл	97,117,800.00	76,030,426.00	<b>21,087,374.00</b>	<b>78.29</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
210104	Урамшуулал	31,353,700.00	31,296,887.00	<b>56,813.00</b>	<b>99.82</b>
210105	Гэрээт ажлын хөлс	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,242,600.00</b>	<b>54,409,394.00</b>	<b>2,833,206.00</b>	<b>95.05</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,277,700.00	38,435,418.00	<b>1,842,282.00</b>	<b>95.43</b>
210202	Тэтгэмжийн даатгал	4,241,200.00	4,226,020.00	<b>15,180.00</b>	<b>99.64</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,393,000.00	3,242,475.00	<b>150,525.00</b>	<b>95.56</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	848,200.00	765,798.00	<b>82,402.00</b>	<b>90.29</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	8,482,500.00	7,739,683.00	<b>742,817.00</b>	<b>91.24</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>104,630,600.00</b>	<b>104,630,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>

**Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210301	Гэрэл, цахилгаан	9,600,000.00	7,259,789.00	<b>2,340,211.00</b>	<b>75.62</b>
210302	Түлш, халаалт	87,870,600.00	90,975,662.00	<b>-3,105,062.00</b>	<b>103.53</b>
210303	Цэвэр, бохир ус	7,160,000.00	6,395,149.00	<b>764,851.00</b>	<b>89.32</b>
210304	Байрны түрээс	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,692,700.00</b>	<b>4,692,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	1,050,000.00	1,158,320.00	<b>-108,320.00</b>	<b>110.32</b>
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	945,000.00	762,280.00	<b>182,720.00</b>	<b>80.66</b>
210404	Ном, хэвлэл	80,000.00	0	<b>80,000.00</b>	<b>0.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,145,200.00	1,158,300.00	<b>-13,100.00</b>	<b>101.14</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,272,500.00	1,413,800.00	<b>-141,300.00</b>	<b>111.10</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,369,900.00</b>	<b>32,850,900.00</b>	<b>14,519,000.00</b>	<b>69.35</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,200.00	154,200.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	37,808,900.00	23,289,900.00	<b>14,519,000.00</b>	<b>61.60</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,406,800.00	9,406,800.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,219,800.00</b>	<b>6,219,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	1,800,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	2,419,800.00	2,419,800.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>380,000.00</b>	<b>380,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	380,000.00	380,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,896,000.00</b>	<b>1,572,000.00</b>	<b>324,000.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	600,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	972,000.00	<b>324,000.00</b>	<b>75.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,463,200.00</b>	<b>1,463,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,463,200.00	1,463,200.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>648,018,700.00</b>	<b>648,018,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>541,988,100.00</b>	<b>541,988,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,988,100.00	541,988,100.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>106,030,600.00</b>	<b>106,030,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	106,030,600.00	106,030,600.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>39,300.00</b>	<b>168</b>	<b>39,132.00</b>	<b>0.43</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>39</b>	<b>39</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1	1	<b>0.00</b>	<b>100.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	<b>0.00</b>	<b>100.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	23	23	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>260</b>	<b>89</b>	<b>171.00</b>	<b>34.23</b>
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>260</b>	<b>89</b>	<b>171.00</b>	<b>34.23</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	260	89	<b>171.00</b>	<b>34.23</b>

**Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39,000.00</b>	<b>39</b>	<b>38,961.00</b>	<b>0.10</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	39,000.00	39	<b>38,961.00</b>	<b>0.10</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,120,000.00</b>	<b>544,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,120,000.00</b>	<b>544,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,120,000.00</b>	<b>544,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		544,000.00
210401	Бичиг хэрэг		0.00
210402	Тээвэр, шатахуун		0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		544,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		0.00
210502	Хоол, хүнс		0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,120,000.00</b>	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		0.00
210604	Урсгал засвар	1,120,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		0.00
<b>210901</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		0.00
<b>213303</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг</b>		0.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>544,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>544,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		<b>544,000.00</b>
131105	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,120,000.00	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>0</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0</b>

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн /цаашид Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг нь “ Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, цэцэрлэг, эцэг, эх олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 683,794.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,837.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 4,786.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,842.2 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага			
Бараа материал	42,602.50	50,331.30	7,728.80
Үндсэн хөрөнгө	476,966.10	429,395.10	(47,571.00)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>519,568.60</b>	<b>479,726.40</b>	<b>(39,842.20)</b>
Өр төлбөр	51,049.70	53,589.30	2,539.60
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	468,518.90	426,137.10	(42,381.80)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>519,568.60</b>	<b>479,726.40</b>	<b>(39,842.20)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 50,331.3 мянган төгрөг болж 7,728.8 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 39,080.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, данс хоорондын шилжүүлгээр 24,435.4 мянган төгрөгийн хангамжийн материал, хандиваар Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 101.0 мянган төгрөгийн тоглоом, БСГ-аас 262.4 мянган төгрөгийн маск, амны хаалт, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 164.5 мянган төгрөгийн халуун хэмжигч, Жайка олон улсын байгууллагаас 73.6 мянган төгрөгийн ариутгалын бодис нийт 601.5 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 30,345.1 мянган төгрөгийн материалыг зарцуулан, байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/42 дугаар тушаалаар 1,607.6 мянган төгрөгийн материалыг акталж, 24,435.4 мянган төгрөгийн материалыг данс хооронд шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 605,088.0 мянган төгрөг болж өмнөх оноос 6,810.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,280.0 мянган төгрөгийн принтер, 520.0 мянган төгрөгийн ус буцалгагч, 2,000.0 мянган төгрөгөөр хүүхдийн хувцасны шкафыг худалдан авсан, 10,610.3 мянган төгрөгийн тоос сорогч, зөөврийн компьютер, 1 болон 2 дугаар хоолны тогоо, самбар, чийрэгжүүлэх тоглоом, программ зэрэг хөрөнгийг Сайхан сумын ИТХТ-ийн 2021 оны А/31 дүгээр тогтоолоор акталж, данснаас хассантай холбоотой байна.

Тайлант оны өглөгийн эцсийн үлдэгдэл 53,589.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 2,539.6 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь 2018 оноос хойш хуримтлагдсан түлш халаалтын өр байна.

Засгийн газрын оролцоо дансны 426,135.1 мянган төгрөг болж 42,381.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 649,164.2 мянган төгрөг болж өмнөх оноос 21,672.9 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Энэ нь 25,293.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 691,334.6 мянган төгрөг болж өмнөх оноос 7,540.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн нь тогтмол зардал 14,319.8 мянган төгрөгөөр өнгөрсөн оноос өссөнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 762,241.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 114,222.3 мянган төгрөгөөр бууруулж, **648,018.7** мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 648,018.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 541,988.1 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 106,030.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 541,988.1 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 106,030.6 мянган төгрөг, нийт 648,018.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **608,610.5** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 39,408.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 608,610.5 мянган төгрөг буюу 93.9 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 21,732.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 2,833.2 мянган төгрөгөөр, норматив зардлыг 14,519.0 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардлыг 324.0 мянган төгрөгөөр нийт 39,408.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгалын санхүүжилтэд 544.0 мянган төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

**3.7.2** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгт 648,018.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 608,610.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 61.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	61.8	1	61.8	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1		1		100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>61.8</b>	<b>2</b>	<b>61.8</b>	<b>100</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,762.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 200.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 31,562.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд бараа материалын дансаар дамжуулалгүйгээр 200.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг шууд зардлаар бүртгэснийг залруулав.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

##### 1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### 1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 31,562.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар цэцэрлэг	3	31,762.3	1	200.0					2	31,562.3